



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 04 өдөр

Дугаар Б/97

Хэрлэн сум

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид шагнал урамшил олгох журам"-ын 5 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Өмнөдэлгэр сумын нутаг дэвсгэрт гарсан ойн түймрийг унтраахад мэргэжлийн ур чадвар идэвх, санаачилга гарган албан үүргээ сайн биелүүлсэн аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Д.Батжаргалыг албан тушаалын сарын цалингийн 40 хувиар шагнасугай.

2. Албан тушаалын сарын цалингийн 40 хувийг аймгийн Онцгой байдлын газрын төсвөөс зарцуулахыг нягтлан бодогч ахлах дэслэгч /Д.Баярсайхан/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА